

Нэг. Тэмцээний зорилго

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын нэр хүндийг дээшлүүлэх, суралцагчдын ур чадварыг ахиулах, мэргэшүүлэх, урамшуулах, дэмжих, тэдний ур чадварын түвшинг олон улсын жишигт хүргэх замаар хөгжлийн чиг хандлага, мэргэжлийн чадвар чадамжийг тодорхойлон, 2021 онд БНХАУ-н Шанхай хотод болох “Дэлхийн ур чадварын 46 дахь тэмцээн”-д оролцох оролцогчийг сонгон шалгаруулах зорилготой.

Ур чадварын тэмцээнийг гурван үе шаттай зохион байгуулах бөгөөд нэгдүгээр шатнаас 5, хоёрдугаар шатнаас 2 шилдэг оролцогчид шалгарна. Шалгарсан 2 оролцогч гуравдугаар шатны тэмцээнд хоорондоо өрсөлдөж шилдэг нь тодорно.

Хоёр. Тэмцээн болох газар, хугацаа

Тэмцээн 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр Улаанбаатар хотод Барилгын Политехник Коллежийн “Барилгын өрөг угсрагч” мэргэжлийн дадлагын байранд зохион байгуулагдана.

Гурав. Тэмцээний хамрах хүрээ

Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь Барилгын өрөг угсрагч мэргэжлээр суралцаж байгаа 2021 оны 12-р сарын 1-ний байдлаар 22 нас хүрээгүй 1 суралцагчийг тэмцээнд оролцуулна.

Дөрөв. Тэмцээн шүүх комиссын бүрэлдэхүүн

Монгол ур чадвар тэмцээний журамд заасан шалгуурыг хангасан, эрх бүхий шүүгчид байна.

Тав. Тэмцээний нийтлэг шаардлага

1. Тэмцээнд оролцогч нь Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагч байх бөгөөд тухайн сургууль албан ёсоор тэмцээнд оролцуулахаар нэр дэвшүүлсэн байна.
2. Тэмцээнд оролцогч нь 2021 оны байдлаар 22 нас хүрээгүй байна.
3. Оролцогч нь тэмцээний ерөнхий зохион байгуулагчийн зүгээс тогтоосон оролцооны төлбөрийг удирдамжинд заасан хугацаанд зохион байгуулагч талд төлсөн байна.
4. Тэмцээнд оролцогчид нь тэмцээний удирдамж, техникийн баримт бичгийг мөрдөж ажиллана.
5. Тэмцээнийг сонирхогчид тодорхой зайнаас ажиглаж болно.

Зургаа. Тэмцээний зохион байгуулалт


Дэлхийн ур чадвар тэмцээний дүрэм, Монгол Ур чадвар тэмцээн зохион байгуулах журам, удирдамжийн хүрээнд зохион байгуулна.

1. Тэмцээнд оролцохыг хүссэн МБСБ-ын суралцагчдыг 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс 02 дугаар сарын 07-ны өдрийн 17.⁰⁰ цаг хүртэл mongolian.builders.federation@gmail.com хаягаар бүртгэнэ. Тэмцээнд оролцох оролцогчийн анкетийг www.Buildersasso.mn цахим хаягаар авах ба Монголын барилгачдын нэгдсэн холбооны байранд хүлээн авна.
2. Тэмцээн 2020 оны 02 дугаар сарын 18 өдөр 09⁰⁰-15⁰⁰ цагийн хооронд Барилгын Политехник Коллежийн “Барилгын өрөг угсрагч” мэргэжлийн дадлагын байранд явагдана.

3. Тэмцээний бэлтгэл ажлыг 2020 оны 02 сарын 16 ны өдөр 10 цагаас БПК-ийн дадлагын байранд хийгдэнэ.Тэмцээнд оролцож байгаа сургуулиудын мэргэжлийн багш нар, оролцогчид заавал оролцох шаардлагатай.
4. Техникийн зөвлөгөөнийг 02 сарын 17-ны 11.00 цагт БПК-ын 205 тоотод зохион байгуулна. Тэмцээнд оролцож буй сургуулиуд болон мэргэжлийн багш, оролцогчид, хөндлөнгийн баталгаажуулагч нар Техникийн зөвлөгөөнд заавал оролцоно.
5. Оролцогчид бүртгүүлэхдээ дараах материалыг бүрдүүлнэ.
 - ✓ Сургуулийн тодорхойлолт
 - ✓ Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ /эх хувиар/
 - ✓ 3х4 хэмжээтэй 2% цээж зураг
 - ✓ Хураамж төлсөн баримт
6. Сургууль тус бүр оролцогчийн хураамжийг бүтгүүлэхээс өмнө төлсөн байх ба нэг оролцогчийн бүртгэлийн хураамж 500,000 төгрөгийг Монголын барилгачдын нэгдсэн холбооны Худалдаа хөгжлийн банк дахь 453035914 тоот дансанд /Монголын барилгачдын нэгдсэн холбоо регистр 1012509/ тушаасан байна. Гүйлгээний утга дээр оролцогчийн сургууль, овог нэр байна. Хураамж төлөгдөөгүй оролцогчийг бүртгэхгүй
7. Тэмцээнийг зохион байгуулагч талууд тэмцээний байр, түүнд хэрэглэгдэх материал, тоног төхөөрөмжийг бэлтгэнэ.
8. Зохион байгуулагдах газар өрөг өрөх талбайг урьдчилан бэлтгэсэн байна.
9. Тэмцээнд оролцогчид эрхийн мандаттай оролцоно.
10. Тэмцээний үеийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг зохион байгуулагч талууд хариуцна.
11. Ажлын даалгаварт MNS 138:2010, MNS 3835:2003, MNS915:1991 стандартын шаардлага хангасан тоосго болон бусад материалыг ашиглана. Орчин үеийн чанарын шаардлага хангахуйц багаж хэрэгсэл сонгож хэрэглэнэ.
12. Тэмцээн тусгай дуут дохиогоор эхлэж, тусгай дуут тохиогоор дуусна. Оролцогч 5 минут ба түүнээс дээш хугацаагаар хоцорсон тохиолдолд тэмцээнээс хасагдсанд тооцно.
13. Ерөнхий шүүгч нь зөрчил гаргасан оролцогчдод холбогдох арга хэмжээ авна.
14. Шүүгч нарын зөвшөөрлөөр тэмцээнийг түр хугацаагаар зогсоож болох бөгөөд тэмцээний хугацаа тооцогдсон хэвээр байх болно.
15. Тэмцээний талбарт мэргэжлийн багш нар, оролцогчид нь хэрүүл маргаан гаргахыг хориглоно. Дээрхи шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд оролцогчийг хасах болно.
16. Тэмцээний талбар руу гар утас оруулахгүй .

Долоо.Ажлын даалгавар

“Монгол ур чадвар-2020” тэмцээний ажлын даалгаврыг /зураг 1/ 5 цаг буюу 300 минутын хугацаанд гүйцэтгэнэ. Ажлын даалгаварт 30%-ийн өөрчлөлт оруулж техникийн зөвөлгөөний хурал дээр танилцуулна. /Жич: Бэлтгэлийн хугацаанд ан заадсан дээр анхаарах/



Найм. Тэмцээнд хэрэглэгдэх гар багаж, хэмжих багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал

Тэмцээнд оролцогчид шаардлагатай гар багаж, хэмжин шалгах багаж хэрэгсэл, тоног төхөөрмжийг өөрсдөө бэлтгэн авч ирэх. Үүнд:

1/ Цахилгаан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж:

а/ Цахилгаан багаж хэрэгсэл тоног төхөөрөмж нь 220В-оор ажилладаг байх шаардлагатай.

- Тоосго зүсэгч машин/сургуулиуд ашиглаж байгаа гар зүсэгч, тоосго зүсэгч машинаа авч ирж болно./
- Уртасгагч залгуур

2/ Хэмжих хэрэгсэл,

- | | |
|-----------------------------|-----|
| - Гортиг | -1ш |
| - Балын харандаа, баллуур | ком |
| - Шугам /1м хүртэлх урттай/ | -1ш |
| - Метр | -1ш |
| - Өнцөг хэмжигч 90° | -1ш |
| - Тэгш ус | ком |
| - Рейк | -1ш |

3/ Гар багаж

- | | |
|---------------------------|-------|
| - Өргийн нийвий | -1ш |
| - Ан заадас засагч | -ком |
| - Өргийн алх | |
| - Чиг утас | -1ш |
| - Ажлын зураг гаргах цаас | -багц |
| - Цаасны хутга | -1ш |

4/ Материал болон зуурмаг

Даалгаварт ашиглагдах бүтэн тоосго, зуурмагт орох материал, зуурмагийг тэмцээний оролцогч бүрт зохион байгуулагч тал урьдчилан бэлдсэн байна.

5/Тэмцээний хугацаа нийт 5 цаг байна. Үүнд цайны завсарлага, амралтын нэг цаг ороогүй.

Санамж:

- Тэмцээнд оролцогч нь хөдөлмөр хамгааллын хувцас өмсөж, хувийн бэлтгэлээ хангасан байна. Үүнд:
 - Ажлын хувцас
 - Нүдний шил
 - Чихэвч эсвэл чихний бөглөө
 - Ажлын гутал
 - Хошуувч/ зүлгэлтийн үед ашиглах
 - Анхны тусламжийн хувийн хэрэгсэл / Жишээ нь: эмчийн хяналтан дор байнга уудаг эм, үнэртүүлэгч, хурууны лент гэх мэт/
- Оролцогч нь тэмцээнд ашиглагдах хэмжин шалгах багажууд, тоног төхөөрөмжийг өөрөө бэлдэж, бүрэн ажилагаатай эсэхийг урьдчилан шалгаж бэлтгэл ажлыг хангасан байх.

Ес. Тэмцээнд оролцогчийн бүтээлд үнэлгээ өгөх, дүгнэх

Тэмцээний даалгаврыг эцсийн бүтээгдэхүүнээр үнэлнэ. Шүүгчид шалгуур үзүүлэлтэд заасны дагуу шалгаж үнэлэх ба дэлхийн ур чадварын тэмцээний стандартыг мөрдөнө.

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

- Ажлын байрны зохион байгуулалт, менежмент, ХАБЭА-г хангах
- Ажлын зураг унших
- Өрөгт бүтээцийн хэмжилт хийх
- Contraction буюу бүтээцийн угсралт, бүтээц гүйцэтгэх
- Өргийн ан заадас, өрөгт бүтээцийн харагдах байдал, өрөгт бүтээцийн гүйцэтгэл

Тэмцээний шүүгч бүр шалгуур үзүүлэлтүүдийг дүгнэхэд оролцож нэгдсэн оноог гаргана. Авсан онооны дарааллаар байр эзлүүлнэ

2020.01.23